

**Засгийн газрын үйл ажиллагааны
2004 оны 11 дүгээр сарын товч мэдээлэл
/2004.10.26.-2004.11.25./**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСАГ

Стратегийн төлөвлөлт, бодлогын хүрээнд

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2005 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн гурав ба түүнээс дээш хүүхэдтэй амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой өрхөд 2005 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн сар бүр 3000 төгрөг олгох, төсвийн байгууллагад ажиллагчдын цалинг 2005 оны 7 дугаар сарын 1-нээс 7.5 хувиар нэмэгдүүлэх, иргэдийн тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх, улмаар 1995 оноос өмнө тэтгэвэрт гарсан тэтгэвэр авагчдын тэтгэврийн зөрүүг багасгах зэрэг тодорхой арга хэмжээг ирэх жилийн үндсэн чиглэлд тусгаж батлуулсан байна.

Монгол Улсын 2005 оны төсвийн тухай хуулийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав. Энэхүү хуулиар 2005 оны төсвийн орлогыг 708,2 тэрбум төгрөг, төсвийн зарлагыг 775,1 тэрбум төгрөг байхаар тогтоов. Ирэх онд төсвийн урсгал тэнцлийн ашгийг 117,1 тэрбум төгрөг, төсвийн нийт тэнцлийн алдагдлыг 66,9 тэрбум төгрөг буюу ДНБ-ний 3.5 хувьтай тэнцүү байхаар баталлаа. Ирэх оны төсөв нийтдээ нийгмийн хамгааллын арга хэмжээнд түлхүү анхаарсан шинж чанартай боллоо. Нийт төсвийн зарлагын 24 хувийг нийгмийн хамгааллын салбарт, 20,8 хувийг боловсролын салбарт, 10,8 хувийг эрүүл мэндийн салбарт зарцуулахаар төлөвлөсөн байна.

Монгол Улсын 2004 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2004 онд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний тодотгосон жагсаалт, түүнчлэн улсын төсвийн болон замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зам, гүүрийн барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалтыг Засгийн газрын тогтоолоор шинэчлэн батлуулав. Энэхүү тогтоолоор барилга байгууламж, төсөл, арга хэмжээг ашиглалтад оруулах хугацаа, тэргүүлэх дараалал, эх үүсвэрийг үндэслэн батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасны зэрэгцээ гүйцэтгэлийн явц, ашиглалтад оруулах хугацаа, тэргүүлэх ач холбогдлыг харгалзан төсвийн ерөнхийлөн захирагчдын саналыг үндэслэн батлагдсан хөрөнгийн дүнд багтаан санхүүжүүлэх, шаардлагатай тохиолдолд зохицуулалт хийж ажиллахыг Сангийн сайдад зөвшөөрөв.

Улсын төсвийн тодотгосон хөрөнгө оруулалтаар 2004 онд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний анх батлагдсан хэмжээ (нийтдээ 12.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 6.0 тэрбумаар хасагдаж) эцсийн дүнгээрээ 6.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Мянганы сорилтын корпорацид Монгол Улсаас өргөн барих төсөл, хөтөлбөрүүдийн талаар Засгийн газрын хуралдаанд танилцууллаа. Монголын талын ажлын хэсэг Мянганы сорилтын корпорациас болзол болгосон зарчмын дагуу олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэг явуулсны үндсэн дээр төсөл, хөтөлбөрүүдийг боловсруулсан байна. Нийт зургаан удаагийн нээлттэй хэлэлцүүлэгт 750 гаруй хүн оролцсон бөгөөд тэдний санал, Мянганы сорилтын корпорациас тавьсан шалгуур үзүүлэлтийг үндэслэн Монголын бизнесийн хөгжил, боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц гэсэн дөрвөн чиглэлээр нийт 252.4 сая ам.долларын өртөг бүхий төсөл, хөтөлбөрүүдийг АНУ-ын талд санал болгохоор бэлтгэсэн байна.

Сангийн яам, “Стандарт энд Пүэрс” компанийн шинжээчдийн жилийн уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтад Монгол улсын дотоод ба гадаад валютын урт, богино хугацааны зээлжих зэрэглэлийг олон улсын санхүүгийн зах зээлд урьд өмнө тогтоосон үнэлгээний талаарх болон Монгол Улсын зэрэглэл тогтоох үйлчилгээтэй холбоотой мэдээ, мэдээллүүдийг “Стандарт энд Пүэрс” компанийн шинжээчдэд танилцуулав. Монгол Улсын зээлжих зэрэглэл тогтоохтой холбогдож гарсан үйлчилгээний хөлсийг улсын төсвийн хуваарилагдаагүй зардлаас гаргах тухай Сангийн сайдын тушаалыг боловсруулан батлуулав.

Азийн хөгжлийн банкны шугамаар Казакстан Улсын Астана хотноо болсон Төв Азийн орнуудын бүсийн эдийн засгийн хамтын ажиллагааны асуудлаархи Сайд нарын бага хуралд үйлдвэр, худалдааны яамны Төрийн нарийн бичгийн дарга тэргүүтэй төлөөлөгчид оролцлоо. Алтайн зурвас замын санхүүжилт, Монгол Улсын ОХУ, БНХАУ-тай байгуулж буй дамжин өнгөрөх тээврийн хэлэлцээрийг түргэвчлэхэд АХБ дэмжлэг үзүүлэх, Далайд гарцгүй орнуудын худалдааны салбарын асуудлыг бүсийн арга хэмжээнд онцгойлон судалж үзэх, Эрчим хүчний салбарын үйл ажиллагаанд судалгаа дүгнэлт хийхдээ Зүүн болон Өмнөд Азийн орнуудаас Монгол Улс нефть, шатдаг хий импортлох асуудлыг оруулах, Монголын хилийн боомтуудыг шинэчлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэрэг саналыг дэвшүүлж, Сайд нарын гурав дахь бага хурлаас гаргасан хамтарсан мэдэгдэлд тусгуулав. Эдгээр саналуудыг тусгуулснаар баруун бүсийн нутагт авто зам тавихад АХБ-наас санхүүжилт авах, гаалийн боомтуудыг сайжруулахад туслалцаа авах, Казакстанаас нефтийн бүтээгдэхүүн авах боломжийг бүрдүүлэх, гурван талын дамжин өнгөрүүлэх тээврийн хэлэлцээрийг урагшлуулахад чухал үүрэг гүйцэтгэх болно.

Бодлогын хэрэгжилтийг зохицуулах хүрээнд

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2004 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр улсын нэгдсэн төсвийн нийт орлого 543.1 тэрбум төгрөгт хүрч төлөвлөгөө 3.6 хувиар давж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 109.7 тэрбум төгрөгөөр буюу 25.3 хувиар өссөн байна. Улсын нэгдсэн төсвийн зарлага 548.0 тэрбум төгрөг болж төлөвлөгдсөн нийт зардлын 97.7 хувийг санхүүжүүлсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс зарлага санхүүжилт 80.8 тэрбум төгрөгөөр буюу 17.3 хувиар өссөн байна. Эхний 10 сарын байдлаар төсвийн урсгал тэнцэл (өссөн дүнгээр) 118.7 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 4.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

Улсын хэмжээнд төсөвт байгууллагуудын 11 дүгээр сарын 1-ний байдлаар нийт авлага 3.9 тэрбум, өр 5.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа мэдээтэй байна.

Улсын төсвөөс 11 дүгээр сард 31,2 тэрбум төгрөгийн зарлага санхүүжилт хийснээс халамжийн тэтгэвэрт 2.4 тэрбум төгрөг, тэтгэврийн нөхөн олговорт 0.1 тэрбум төгрөг, тэтгэврийн даатгалын санд 2,2 тэрбум төгрөг, төрөөс хариуцах эрүүл мэндийн даатгалын хураамжид 0.5 тэрбум төгрөг, цагаатгалын нөхөн олговорт 60,0 сая төгрөг олгосон байна. Орон нутгийн төсөвт олгох 11 дүгээр сарын НӨАТ-ын тооцоог хийж, нийтдээ 1,1 тэрбум төгрөгийн НӨАТ-ын буцаан олголтыг шилжүүлэв. Засгийн газар 2004 оны эхний 11 сарын байдлаар үнэт цаасны (бондын) үндсэн төлбөрт 47.3 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 1.5 тэрбум (бүгд 48.8 тэрбум) төгрөгийг төлсөн байна.

2004 оны 10 дугаар сарын байдлаар нийтдээ 94,1 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний гадаадын зээлийг ашигласан дүн мэдээтэй байна. Арилжааны банкуудаас Дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу эхний 11 сард зээлийн үндсэн төлбөрт 1.1 тэрбум, хүүгийн төлбөрт 7.1 тэрбум (бүгд 8.2 тэрбум) төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авлаа. Засгийн газар 2004 оны эхний 11 сарын байдлаар гадаад зээлийн үндсэн төлбөрт 63.5 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 16.3 тэрбум (бүгд 79.8 тэрбум) төгрөгийг төлсөн байна.

Төрийн захиргааны удирдлагын хүрээнд

Туркийн Ерөнхий сайдын дэргэдэх Гадаад худалдааны асуудал хариуцсан Төрийн нарийн бичгийн дарга, Туркийн ЭКЗИМ банкны төлөөлөн удирдах зөвлөлийн дарга тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авах ажлыг зохион байгуулав. Туркийн төлөөлөгчдийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол улсын Шадар сайд, Сангийн сайд нартай уулзуулж, хоёр талын хамтын ажиллагааны Протоколд гарын үсэг зурах ажлыг зохион байгуулав.

БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд БНХАУ-д зохион байгуулагдаж буй “Жижиг, дунд үйлдвэрийн хөгжил”, “Банк санхүүгийн зах зээл” сэдэвт сургалтуудыг зохион байгуулав. БНХАУ-ын Засгийн газраас Худалдаа, аж үйлдвэрийн танхимын барилгыг барихад зориулан олгож буй 4 сая ам. долларын буцалтгүй тусламжийн хүрээнд БНХАУ-ын талаас ирсэн судалгааны багтай уулзалт зохиож, хоёр тал гэрээнд гарын үсэг зурах ажлыг зохион байгуулав.

Монгол Германы Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгээс хэрэгжүүлж байгаа “Байгаль хамгаалал ба байгалийн нөөцийн тогтвортой менежемент” төслийг 2005 оноос хөтөлбөр болгох төлөвлөлтийн семинарыг зохион байгуулж, семинарын үр дүнд протоколд гарын үсэг зуруулав.

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа төслүүдийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа, санхүүгийн удирдлага ба санхүүжилтийн журмын тухай семинарыг хамтран зохион байгуулав. Мөн Азийн хөгжлийн банктай хамтран “Төслийн хэрэгжилт, удирдлага, зохион байгуулалт” сэдэвт семинар зохион байгууллаа. Тус семинараар бараа, материал худалдан авах ажиллагаа, зөвлөх сонгон шалгаруулах, гадаадын зээл, тусламжийн хөрөнгийг шилжүүлэх, ашиглах тухай АХБ-ны журам, дүрмийг танилцуулан, сертификат олгов.

Засгийн газрын худалдан авах ажиллагааны чадавхийг хөгжүүлэх тогтвортой сургалтын тогтолцоо бүрдүүлэх, улсын хэмжээнд сургалтын сүлжээ үүсгэх зорилгоор Азийн хөгжлийн банктай хамтран Засгийн газрын худалдан авах ажиллагааны сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулав. Сургалтаар бэлтгэгдсэн сургагч багш нар хөтөлбөрийн дагуу их, дээд сургууль, төрийн болон төрийн бус байгууллага зэрэг газарт Засгийн газрын худалдан авах ажиллагааны талаарх сургалтыг хөтлөн явуулах чадвартай болсон гэж үзэж байна. Түүнчлэн сургагч багш нар Дэлхийн банктай хамтран 2005 онд улсын хэмжээнд худалдан авах ажиллагааны чиглэлээр зохион байгуулах сургалт болон бусад сургалтад сайн дурын үндсэн дээр оролцох эрх эдэлнэ.

ҮЙЛДВЭР, ХУДАЛДАА

Үйлдвэрийн бодлого, зохицуулалтын талаар

Монгол-Австрийн Засгийн газар хоорондын хуралдаан болохтой холбогдуулж, модны үйлдвэрлэлийн чиглэлээр хэрэгжүүлэх асуудлаар санал боловсруулаад байна.

Турк-Монголын Засгийн газар хоорондын комиссын хуралдааны бэлтгэл хангах, туркийн талын ажлын хэсэгт оролцож, арьс ширний үйлдвэрийн парк байгуулах төслийг хэрэгжүүлэх асуудлаар санал солилцож, төсөл боловсруулах ажлын хэсэ байгуулах тухай сайдын тушаал гаргав.

Экспорт, импортын гаалийн тарифын хувь, хэмжээнд өөрчлөлт оруулах асуудлаар мэргэжлийн холбоодоос санал авч нэгтгэж байна.

Оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих зөвлөлийн үйл ажиллагааны төслийг боловсруулаад байна.

Геологи, эрдэс баялгийн бодлого, зохицуулалтын талаар

Төхөм-Х, Богд-IV талбайн 1:200000-ны масштабын хүндийн хүчний судалгааны 2004 оны хээрийн материал, улсын геологийн 1:200000 масштабын зураг зохиох төслийн хээрийн материалыг тус тус хүлээн авлаа.

Замын-Үүдийн усан хангамжийн чиглэлээр хэрэгжүүлж буй Японы JICA-ийн төслийн явцыг хэлэлцэх семинар болов.

Тавтын алтны үйлдвэрийн туршилтын ажлын төсөлтэй танилцан шаардлагатай зарим материалын зөвшөөрөл гаргуулав.

Худалдааны бодлого, хамтын ажиллагааны талаар

Казахстаны Астана хотноо болсон Төв Азийн эдийн засгийн хамтын ажиллагааны асуудлаарх сайд нарын III бага хуралд оролцов.

Туркийн Гадаад худалдаа эрхэлсэн сайд Т.Каяалар тэргүүтэй туркийн төлөөлөгчдийн Монголд хийсэн айлчлалыг зохион байгуулав.

Эрхүү мужийн Амбан захирагчийн Монголд хийх айлчлалын бэлтгэл хангаж, уулзалтуудыг зохион байгуулав.

Шведийн 20 гаруй ажил хэрэгч хүмүүсийн Монголд хийх уулзалтууд, дугуй ширээний ярилцлагыг зохион байгуулж, манай улсын эдийн засгийн байдал, хоёр орны хамтын ажиллагааны асуудлаар илтгэл тавив.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН

Бага, дунд боловсролын талаар:

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор ЕБС-ийн сурах бичиг, багшийн хөгжлийн асуудлаар хэрэгжүүлэх зорилт, стратегийг тодорхойлов.

БСШУЯ-нд нэгдмэл үйлчилгээт тоон сүлжээний технологид тулгуурласан “Боловсролын зайны сургалтын үндэсний системийн төв”-ийг байгуулж, нээлтийн ажиллагааг зохион байгуулав. Зайны сургалтын төвийн нээлтэд Монгол Улсын Ерөнхий сайд оролцож, сүлжээгээр 14 аймагтай холбогдон орон нутгийн өвөлжилт болон цаг үеийн асуудлаар ярилцав. Боловсролын зайны сургалтын энэхүү систем нь багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтыг зайнаас зохион байгуулах, олон улс болон аймгуудтай видео хурал, уулзалт хийх, статистик мэдээллүүдийг сүлжээгээр авахаас гадна боловсролын электрон мэдээллийн сүлжээг байгуулах үндсэн дээр боловсролын удирдлагын мэдээллийн нэгдсэн санг бий болгох зэрэг өргөн боломжуудыг бий болгож байгаагаараа ач холбогдолтой юм.

Шведийн олон улсын хамтын ажиллагааны байгууллага (SIDA)-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх “Монгол дахь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол” төслийн хэрэгжилтийг зохицуулан удирдах багийг байгуулж, ажил хэргийн уулзалт 2 удаа зохион байгуулж, төслийг хэрэгжүүлэх стратегийг тодорхойлов.

НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран хэрэгжүүлдэг “Суурь боловсрол” хөтөлбөрийн хүрээнд “Бага боловсролын сурлагын амжилтын үнэлгээ” судалгааг аймаг, нийслэлийн 21 сургуульд зохион байгууллаа. Энэхүү судалгаагаар суралцагчдын сурлагын амжилтад нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлж, үр дүнг цаашдын үйл ажиллагаандаа хэрэглэх боломж бүрдлээ.

11 жилийн сургалттай ЕБС-ийн 1 дүгээр ангийн казак хэлний сурах бичиг зохиолгож, хэвлэлд шилжүүлэв. АХБ-ны санхүүжилтээр боловсролын шинэ стандартад нийцүүлэн бэлтгэж, хэвлэх “Хими-10” сурах бичгийн сурагчийн болон багшийн номын зохиолын эхийг бэлэн болгов.

Бага, дунд боловсролын стандартын туршилтыг эрчимжүүлэх, түүнийг сайжруулах хүрээнд “Туршилтын үр дүнг тусган стандартуудыг сайжруулах аргачлал” семинарыг зохион байгуулж, стандартуудыг сайжруулах аргачлал, зөвлөмжийг боловсруулж гаргалаа.

“Сурах бичгийн эрх зүйн баримт бичгүүдийг шинэчлэх арга зүй” сэдэвт бодлого боловсруулагч, хуульчид, эх зохиогч, хэвлэн нийтлэгч нарт зориулсан 3 хоногийн сургалтыг зохион байгуулж, сурах бичгийн эрх зүйн баримт бичгүүд болох үзэл баримтлал, бодлого, холбогдох журмууд, стандартын төслүүдийн анхны хувилбаруудыг боловсруулав.

Өвөрхангай аймгийн Боловсрол, соёлын газар болон тус аймгийн “Шинэ зуун” бүсийн санаачилгаар бүсийн сургуулиудын 330-аад багшийг оролцуулсан “Боловсролын шинэ стандартыг хэрэгжүүлэх арга зүй” сэдэвт 3 хоногийн сургалтыг Өвөрхангай аймагт зохион явуулав.

Харааны согогтой хүүхдийн 116 дугаар тусгай сургуулийн засварын ажлыг хүлээн авч, хичээлийн байрны өмчлөлийн асуудлыг Төрийн өмчийн хорооны тогтоолоор шийдвэрлүүлэв.

2003-2004 оны хичээлийн жилд аймаг, нийслэлийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарт багшлах эрх олгосон тухай танилцуулгыг бэлтгэж, Багшлах эрхийн хорооны ээлжит хурлаар хэлэлцүүлэв. Багшлах эрх олгох ажлын хүрээнд Баян-Өлгий, Булган, Дархан-Уул, Өмнөговь аймгийн анхны жилдээ ажиллаж байгаа багш нарын материалыг судлан 59 багш, багшлах эрх авч чадаагүй 68 багшид эрх олгоод байна. Энэхүү ажлын хүрээнд мэргэжлийн бус багш нарыг сургалтад хамруулсан нь тэдний мэргэжлийг дээшлүүлэхэд тодорхой нөлөө үзүүлж байна.

Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын талаар:

“Сургалтын баримт бичиг боловсруулах журам” боловсруулж, батлуулсны зэрэгцээгээр “Монгол Улсад магистр, докторын зэрэг олгох хамтарсан сургалт эрхлэх түр журам”-ын төсөл боловсруулж, яамны нэгжийн дарга нарын зөвлөлгөөнөөр хэлэлцүүлэв.

1991-2004 онд байгуулагдсан дээд боловсролын сургалтын байгууллагуудын нэгдсэн бүртгэлийг цэгцлэв.

2005-2006 оны хичээлийн жилээс гадаадын их, дээд сургуулийн магистрантур, докторантурт суралцуулах мэргэжлийн чиглэл, хяналтын тооны талаар яамд, агентлагийн санал авч нэгтгэв.

Шинжлэх ухааны оны шилдэг бүтээлийн уралдаанд ирүүлсэн 22 бүтээлийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, оны шилдэг бүтээлүүдийг шалгаруулж, урамшуулал олгов.

2005 оноос шинээр эхлэн хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн төслүүдийн талаар яамдын саналыг авч, тусгай комисс томилон сонгон шалгаруулалт хийж эдгээрийн гүйцэтгэгчдийг шалгаруулах зарыг хэвлэлд гаргалаа.

Эдийн засаг, мэдээлэл, хяналт-шинжилгээний талаар:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдах Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 240 ортой цэцэрлэгийн барилга, Ховд аймгийн Дарви сумын соёлын төв, Завхан аймгийн Улиастай сумын сургуулийн өргөтгөлийн барилгын тендерийг хүлээн авч үнэлгээнд оруулан дүгнэж байна.

Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар их засвар хийсэн Улаанбаатар хотын 79 дүгээр сургууль, Завхан аймгийн Тосонцэнгэл сумын 1 дүгээр сургууль, Төв аймгийн Зуунмод хотын 4 дүгээр сургуулийн засварын ажлыг дуусгаж хүлээн авав.

Сургуулийн өмнөх, бага, дунд, дээд боловсролын 2004-2005 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийг аймаг, нийслэлээс хянан хүлээн авч, боловсруулалт хийж байна. Түүнчлэн боловсролын салбарын 2003-2004 оны хичээлийн жилийн статистикийн мэдээлэл, соёл, урлаг, шинжлэх ухаан, технологийн статистикийн мэдээллийг хэвлүүлэхээр бэлтгэв.

Соёл, урлагийн талаар:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Засгийн газарт өгсөн чиглэлийн дагуу “Морин хуур, уртын дуу” үндэсний хөтөлбөрийн төсөл боловсрууллаа.

“Бүгд Найрамдах Улс тунхагласны 80 жилийн ой”-д зориулсан “Тусгаар тогтнол” сэдэвт уран бүтээлийн үзэсгэлэн, гэрэл зураг, уран бүтээл, музейн үзмэрээс бүрдсэн үзэсгэлэнг тус тус зохион байгуулав.

Япон Улсын Засгийн газраас 2006 оны санхүүгийн жилд хэрэгжүүлэх дараах төслүүдийг боловсруулав:

- “Хархорум музей, судалгаа шинжилгээ, мэдээллийн төвийг байгуулах тухай”
- “Ховор нандин номыг хадгалж хамгаалах тухай”
- “Галлерейн сан хөмрөгийн тоног төхөөрөмжийг шинэчлэх тухай”

Гадаад харилцаа, захиргааны удирдлагын талаар:

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө(2004-2008 он) болон эдийн засаг нийгмийг 2005 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг тус тус боловсруулж ХЭГ-т хүргүүлэв. Түүнчлэн Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

“Соёлын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Украин Улсын сайд нарын танхим хоорондын Хэлэлцээр”-ийн төсөл, Монгол-Францын соёл, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны хамтарсан комиссын 14 дүгээр хуралдааны Протокол, “Монгол Улсын БСШУЯ, Бүгд Найрамдах Болгар Улсын соёлын яам хооронд соёлын салбарт хамтран ажиллах тухай Төлөвлөгөө”, “Монгол Улсын БСШУЯ, Бүгд Найрамдах Унгар Улсын

Боловсролын яам, Үндэсний соёлын өвийн яам хооронд боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт 2004-2006 онд хамтран ажиллах тухай Төлөвлөгөө"-ний төслийг тус тус боловсруулав.

ЭРҮҮЛ МЭНД

Хүн амын эрүүл мэндийг хамгаалах талаар

Монголын окутнй анхдугаар их наадмыг зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг баталж, их наадмыг 2004-2005 рны хичээлийн жилд зохион байгуулахаар болов.

Эрхтэн шилжүүлэн суулгасны дараах дархлаа дарангуйлах эмийн зардалд 95.0 сая төгрөгийг Клиникийн нэгдсэн 1 дүгээр эмнэлэгт, хорт хавдрын эмчилгээ, оношлогоонд учирч байгаа санхүүжилтийн хүндрэлтэй байдлыг арилгах зорилгоор хавдар судлалын төвд 40.0 сая төгрөг тус тус олголоо.

Иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайжруулах, клиникийн болон төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг, төвийн менежментийг боловсронгуй болгох зорилгоор “Эмнэлгийн менежментийг боловсронгуй болгох” төсөл шалгаруулах уралдааны болзол, боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлаад байна.

“Ном, сурталчилгааны материал хуваарилах тухай” Эрүүл мэндийн сайдын тушаалаар сум, өрхийн эмч нарын өдөр тутмын үйл ажиллагаанд зориулан ДЭМБ-тай хамтран хэрэгжүүлж буй халдварт бус өвчин” төсөл, “Осол гэмтлээс сэргийлэх” дэд төслийн шугамаар хэвлэгдсэн “Хэрэх өвчний урьдчилан сэргийлэлт, оношлогоо, эмнэлзүйн удирдамж”, “Чихрийн шижин өвчний эмнэлзүйн удирдамж”, “Цусны даралт ихсэх өвчний эмнэлзүйн удирдамж”, “Нийгэм хамт олонд тулгуурласан сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ” номууд болон мэдээлэл, сургалт, сурталчилгааны материалыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилан олголоо.

Дэлхийн мянганы хөгжлийн “Эхчүүдийн эрүүл мэндийг сайжруулах, эхийн эндэгдлийг 2015 он гэхэд 1990 оны түвшнээс дөрөвний гурваар бууруулах зорилт”-ыг хэрэгжүүлэх зорилгоор эхийн эндэгдлийг бууруулах стратеги төлөвлөгөөг боловсруулан энэ оны 12 дугаар сарын 10-ны дотор семинар зохион байгуулж, хот хөдөөгийн эрүүл мэндийн байгууллагын асуудал хариуцсан эмч мэргэжилтнүүдийн саналыг тусган батлуулахыг ажлын хэсгийн ахлагчид даалгав.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар

Томуу, томуу төст өвчний лабораторид суурилсан харуулдан тандалтын сүлжээг нэвтрүүлэх зорилгоор тандалтын багийн бүрэлдэхүүн, ТТӨ-ний харуулдан тандах цэгийн жагсаалт, тандах цэгийн ажиллах журам, ТТӨ-ний шинжлэгдэхүүн авах, хадгалах, тээвэрлэх, шинжлэх журмыг тус тус баталж, ТТӨ-ний харуулдан тандалтын сүлжээнд шаардагдах хөрөнгийг төвлөрсөн төсөв болон олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрт тусган хэрэгцээт оношлуур, тоног төхөөрөмжөөр хангахыг Төрийн нарийн бичгийн даргад үүрэг олгов.

Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийг илрүүлэх, мэдээлэх, тандах үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн тандалтад үнэлгээ өгөх комиссын бүрэлдэхүүнийг батлан ажиллуулж байна.

“100 хувь бэлгэвч хэрэглэх хөтөлбөрийг улсын хэмжээнд нэвтрүүлэх нь” сэдэвт семинарыг Улаанбаатар хот, аймгуудад зохион байгуулав. Уг семинараар хүн ам төвлөрсөн баар, зочид буудал, цэнгээний газар болон биеэ үнэлэгч ихтэй Улаанбаатар хот, бүх аймгийн төвүүдэд уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь чухал болохыг онцолж хамтарч ажиллахаар болов.

Улсын хэмжээнд оны эхний 10 сарын байдлаар вируст гепатит А өвчин өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.7%-аар, 5 жилийн дунджаас 7.5%-аар тус тус буурсан хэдий ч нийслэлийн 83, 124, 141 дүгээр цэцэрлэг, 3, 42, 48, 72, 92 дугаар сургуулиудад дэгдэлт хэлбэрээр гарлаа. Нийслэлийн цэцэрлэг, сургуулийн хүүхдийн нягтрал 2-3 дахин ихэссэн, гар угаах нөхцөл бүрдээгүй, зөв дадал, хандлага хэвшээгүй, бие засах газрын суултуур, цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжилтийн бодис хүрэлцээгүй, хэрэглэж хэвшээгүй, гутлын гадуурхи улавчийг буруу хэрэглэсэн, гал тогоо, цайны газрын ариун цэвэр, эрүүл ахуйн дэглэм зөрчигдсэн зэрэг нь

өвчлөл голомтлон гарахад нөлөөлж байгааг мэргэжлийн хяналтын байгууллага тогтоосон байна. Энэ байдалд дүгнэлт хийж, дараах арга хэмжээнүүдийг авч байна:

- Вируст гепатит А өвчинтэй тэмцэх, сэргийлэх талаар авах арга хэмжээийг чиглэл боловсруулан аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлэв.
- ЭМЯ, БСШУЯ, УМХГ-ын удирдах албан тушаалтнуудын хамтарсан хурлаар “Халдварт өвчний өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээ”-ний талаар хэлэлцэж хамтарсан албан даалгавар гаргаж хэрэгжүүлэхээр боллоо.
- Вируст гепатит А өвчний өвчлөл ихтэй нийслэлийн сургууль, цэцэрлэгүүдэд нарийн мэргэжлийн эмч нарын баг ажиллуулж, шаргүй далд хэлбэрийн вируст гепатит А-г илрүүлэх үзлэгт 6694 хүүхдийг хамруулан 18 хүүхдийг тусгаарлан, нийслэлийн 106 сургууль, 154 цэцэрлэгийг ариутгах арга хэмжээг зохион байгуулав.
- Нийслэлийн 116 өрхийн 550 гаруй өрхийн эмч нарт “Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчний тандалт, сэргийлэлт” сэдэвт сургалт семинарыг зохион байгуулав.
- Вируст гепатит А өвчний талаар уулзалт, ярилцлагыг холбогдох байгууллагуудтай хамтран 3 удаа зохион байгуулав.
- “Гэдэсний халдвараас сэргийлье” сэдэвт радио, телевизийн цуврал хичээлийг 6 удаа явуулж, энэ чиглэлээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр 84 удаа сурталчлаад байна.

2004 оны эхний 10 сарын байдлаар 37273 эх амаржиж, 37216 амьд хүүхэд төрсөн байна. Энэ хугацаанд 39 эх эндэж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 1 тохиолдлоор, сүүлийн 5 жилийн дунджаас 14 тохиолдлоор буурсан байна.

0-1 насны 817 хүүхэд эндсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 37-оор сүүлийн 5 жилийн дунджаас 260 тохиолдлоор буурсан байна. 1-5 насны 236 хүүхэд эндэж өнгөрсөн оны үеийнхтэй харьцуулахад 49 тохиолдлоор, сүүлийн 5 жилийн дунджаас 116-аар буурсан байна.

Мөн хугацаанд халдварт өвчний 24614 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 2381-өөр нэмэгдэж, сүүлийн 5 жилийн дунджаас 3608-аар буурч, 10000 хүн амд халдварт өвчний 91.4 тохиолдол ногдох боллоо.

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨР

Нийгмийн хамгааллын талаар авсан арга хэмжээ, үр дүнгийн үнэлгээ:

Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай УИХ-ын тогтоолын төсөл боловсруулж, яамдын болон Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, МҮЭ-үүдийн Холбооны саналыг авч тусган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэв. Хуралдаанаас тогтоолын төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтов.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу амьжиргааны доод түвшингөөс доогуур орлоготой өрхийн гурав ба түүнээс дээш тооны хүүхдэд сар тутам олгох тэтгэмжийн талаар “Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулав. Үүнтэй холбогдуулан Засгийн газраас амьжиргааны доод төвшингөөс доогуур орлоготой өрхийн гурав ба түүнээс дээшхи 0-18 хүртэлх насны хүүхдэд тэтгэмж олгох журмын төслийн эхний хувилбарыг боловсруулаад байна.

Олон улсын тахир дутуу хүмүүсийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хүний эрхийн үндэсний комисс, МТДИБҮХолбоо хамтран “Нийгмийн тэгш оролцоо” сэдэвт сургалт семинарыг тахир дутуу иргэдийн эрх ашгийг хамгаалсан ТББ-уудын удирдах ажилтнууд, төрийн байгууллагын ажилтнуудын хүрээнд зохион байгуулав.

Монгол Улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банкны шугамаар Японы ядуурлыг бууруулах сангаас санхүүжигдэж буй “Тахир дутуу иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх” төслөөс Тахир дутуу иргэдийн Мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төвд тахир дутуу иргэдэд зориулж засварласан бие засах загвар хоёр өрөөг хүлээлгэн өглөө. Тахир дутуу иргэдэд тав тухтай орчин бүрдүүлэх үүднээс хийж гүйцэтгэсэн энэ ажилд 4 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна.

Хүн амын бодлого, төсөв, хөрөнгө оруулалтын асуудлаар

Гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн ажлын хүрээнд нийслэлийн зарим хороодын нийгмийн ажилтнуудад зориулан “Гэр бүлийн хөгжил” сэдэвт 40 цагийн сургалт зохион байгуулав. Энэхүү сургалтаар гэр бүлийн хөгжлийг дэмжих талаар төрөөс баримталж буй бодлого, түүнийг хэрэгжүүлэхэд нийгмийн ажилтны үүрэг оролцоо, гэр бүлтэй ажиллах арга зүйн талаар онолын ойлголт өгч, дадлага хийлгэв. Сургалтыг зохион байгуулснаар хорооны нийгмийн ажилтан, зохион байгуулагчдын ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, нийгмийн ажлын арга зүйд сургах эхний алхам болсноороо ач холбогдолтой боллоо.

Гэр бүлийн жилийн ажлын хүрээнд хараа хяналтгүй, халамжийн төвд амьдарч байгаа 200 гаруй хүүхдийг бичиг баримтжуулах ажлыг зохион байгуулж эхлээд байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 30 гаруй халамжийн төвд нийт 1160 гаруй хүүхэд амьдарч байгаагаас дээрх 200 хүүхэд бичиг баримтгүй байсан бөгөөд 50 хүүхдэд нь иргэний үнэмлэх, үлдсэнд нь төрсний гэрчилгээ олголоо.

Хүүхдийг бэлгийн зорилгоор ашиглах, хил дамжуулан худалдахаас хамгаалах Үндэсний хөтөлбөрийн төсөл хэлэлцэх уулзалтыг зохион байгуулав. Энэхүү хөтөлбөрийг боловсруулах асуудлаар салбарын яамд, Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв, Хил хамгаалах ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба, НҮБ-ын Хүүхдийн сан болон ТББ-ын төлөөлөл бүхий салбар дундын ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа юм.

Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, цалин хөлсний бодлогын талаар :

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон, хохирлыг нь хариуцах аж ахуйн нэгж, байгууллагагүй нэр бүхий 10 иргэнд нөхөн төлбөр олгох асуудлыг шийдвэрлэв.

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын төлөөлөгчид Улаанбаатар хотноо Монголын нийгмийн түншлэгч талуудын удирдлагуудтай уулзаж харилцан зөвлөлдсөний үндсэн дээр үйлдвэр дээрх менежментийн сургалт, гурван талт харилцааны чадавхийг дээшлүүлэх, ажлын байран дахь сургалт чиглэлүүдээр хамтран ажиллахаар тохиролцож дээрх чиглэлүүдээр “Нийгмийн түншлэлийн механизмыг боловсронгуй болгож чадавхийг бэхжүүлэх” төслийг хэлэлцэж шийдвэрлэх шатандаа явж байна.

“Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” хуулийн дагуу “Адана” ХХК, “Мөхөт” ХХК, “Кон Арт” Монголын орчин үеийн урлагийн төвийн Япон улсын холбогдох компаниудтай байгуулсан гэрээний дагуу нийт 18 хүнийг Япон улсад, “Реалит Центр” ХХК-ын БНЧех Улсын холбогдох компанитай байгуулсан гэрээний дагуу 2 хүнийг Чех Улсад, “Монгол ньус” ХХК-ний БНСУ-ын Жижиг дунд, үйлдвэрийн Холбоотой байгуулсан гэрээний дагуу 128 хүнийг үйлдвэрлэлийн дадлагажигчаар илгээх асуудлыг шийдвэрлэв.

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны талаар:

БНБУ-ын Нийгмийн бодлого, хөдөлмөрийн яамтай байгуулсан хамтын ажиллагааны Меморандумыг 2005-2006 онд хэрэгжүүлэх Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловруулж, Болгарын талтай харилцан тохиролцох шатандаа явж байна. Мөн БНБУ-ын Нийгмийн бодлого, хөдөлмөрийн сайд Христина Христоваг 2005 оны эхний улиралд багтаан Монгол Улсад айлчлуулахаар тохиролцов.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн удирдлагын систем нэвтрүүлэх удирдамжийг өөрийн орны онцлог нөхцөл байдал болон ОУХБ-ын удирдамжтай нийцүүлэн боловсруулж, түүнийг төрийн бодлогод тусган хэрэгжүүлэхэд бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгчдийн чадавхийг дээшлүүлэх, олон түмэнд ойлголт өгөх зорилгоор ОУХБ-аас мэргэжил, арга зүйн зөвлөгөө авах үндэсний бага хурлын санал, урьдчилсан хөтөлбөрийг БНСУ-ын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн агентлаг болох KOSHA-д танилцуулж хэлэлцэх шатандаа явж байна.

“Монгол Улсын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг хянах, сайжруулах” семинарыг 2005 оны 1 сарын 11-12 зохион байгуулахаар ОУХБ-тай тохиролцож санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэв.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн талаар:

2004 оны эхний 10 сард нийгмийн даатгалын тэтгэвэрт 90,7 тэрбум төгрөг олгохоос 90,4 тэрбум төгрөг олгосон байна. Завхан аймагт нийгмийн даатгалын тэтгэврийн 302,0 сая төгрөгийг хугацаанд нь олгоогүй байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогот 79,6 тэрбум төгрөг оруулахаас 87,8 тэрбум төгрөг оруулж төлөвлөгөөг 110,3 хувиар биелүүлжээ. Нийгмийн даатгалын тэтгэврийн санхүүжилтэд 87,5 тэрбум, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтэд 16,0 тэрбум, тэтгэмжийн даатгалын санхүүжилтэд 3,5 тэрбум, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын санхүүжилтэд 3,1 тэрбум, ажилгүйдлийн даатгалын санхүүжилтэд 750,8 сая төгрөг, нийгмийн даатгалын санхүүжилтэд нийт 110,9 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Нийгмийн даатгалын шимтгэл, хураамжийн авлага 10,2 тэрбум төгрөг байгаагийн 9,0 тэрбум нь аж ахуйн нэгж байгууллагаас, 1,2 тэрбум нь төсөвт байгууллагаас авах авлага байна.

Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн талаар:

2004 оны эхний 10 сард нийгмийн халамжийн тэтгэврийг 46071 хүнд олгож, 5,8 тэрбум төгрөг, нийгмийн халамжийн тэтгэмжийг 150909 хүнд олгож, 9,2 тэрбум төгрөг тус тус зарцуулсан байна.

Нийгмийн халамжийн болон асрамжийн үйлчилгээнд 18880 хүн хамрагдаж 405,6 сая төгрөг, тахир дутуу иргэнд үзүүлсэн нийгмийн халамжийн үйлчилгээнд 20279 хүн хамрагдаж 829,1 сая төгрөг, ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт үйлчилгээнд 86520 хүн хамрагдаж 2,3 тэрбум төгрөг тус тус зарцуулжээ. Нийгмийн халамжийн үйлчилгээнд нийт 324955 хүн хамрагдаж 19,4 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдлын талаар:

Хөдөлмөр эрхлэлтийн албадад ажил идэвхтэй хайж бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо 37,6 мянга болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1714 хүнээр буюу 4,6 пунктээр нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд нийт 28589 иргэнийг ажилд зуучлан оруулсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1265 хүнээр нэмэгдсэн буюу 104,6 хувьтай байна. Нийт ажилд зуучлагдан орсон хүмүүсийн 65,5% нь тахир дутуу одой, эмзэг бүлгийн иргэд, 25,6% нь сургалтанд хамрагдсан иргэд байна.

16891 ажилгүй иргэдийг мэргэжлийн сургалтанд хамруулж, үүнээс 9917 нь буюу 58,7 хувь нь сургалтын дараа ажлын байраар хангагдсан байна.

Нийтийг хамарсан зохион байгуулалттай ажилд 13874 ажилгүй иргэдийг хамруулж түр ажлын байраар хангалаа.

Хөнгөлттэй нөхцлөөр тэтгэвэрт гарсан 6760 хүнд 1557781,4 мянган төгрөгний нөхөн олговор олгож, 1929 хүн нөхөн олговор олгох бүртгэлтэй хүнээс хасагдан, өндөр насны тэтгэвэр авах эрх нь үүссэн байна.

Ажилгүйдлийн тэтгэмжинд нийт 3941 хүн хамрагдсан нь нийт ажилгүй иргэдийн 5,0 хувь нь байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэтгэмжинд хамрагдсан хүний тоо 362 хүнээр буурч 91,6 хувьтай байна.

БАЙГАЛЬ ОРЧИН

Байгаль орчны эрх зүйн орчныг боловсронгуй болгох, стратегийн бодлогын хэрэгжилтийг хангах чиглэлээр:

УИХ-ас баталсан “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-ийн Байгаль орчны төлөв байдлын тухайн жилийн тайланг “Байгаль орчны тухайн жилийн төлөв байдал”, “Байгалийн нөөц баялгийн хувьсал өөрчлөлт”, “Орчны бохирдлын эх үүсвэр, түвшин, түүнийг бууруулах талаар авсан арга хэмжээ, үр дүн”, “Байгалийн нөөц баялгийн нөхөн сэргээлт, хамгаалалт, түүнд зориулсан улсын төсвийн болон төсвийн бус хөрөнгийн зарцуулалт” гэсэн 4 бүлэгтэйгээр нэгтгэлээ.

“Рашаан усны төлбөрийн тухай хууль”-ийн төсөл, Цэвэр хөгжлийн механизмын товчоо байгуулах төсөл, “Итгэлийн арван мянга хууль”-ийн төсөл зэрэгт санал боловсрууллаа.

НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр гадаад дотоодын 70 гаруй эрдэмтэн, судлаач, төлөөлөгч нар оролцсон “Мазаалай баавгай хамгаалал ба менежмент” олон улсын бага хурлыг Их говийн экосистем, түүний шүхэр зүйлийг хамгаалах төсөл, Зэрлэг амьтан ургамлын менежментийн сантай хамтран зохион байгууллаа.

Мөн ШУА-ийн биологийн хүрээлэнтэй хамтран “Азийн орнуудын биотехнологийн сүлжээ” үндэсний семинар, Ирвэс хамгаалах төвтэй хамтран “Монгол орны цоохор ирвэс хамгаалах үндэсний хөтөлбөр” сэдэвт уулзалт ярилцлагуудыг зохион байгуулав.

Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжсэн “Цаг уурын мэдээллийн сүлжээг сайжруулах” төслийн хүрээнд 14 аймгийн төвд цаг уурын автомат станц, 20 аймгийн төвд хиймэл дагуулын холбооны төхөөрөмжийг суурилуулаа.

Хиймэл дагуулын, VSAT-ийн холбоонд шилжсэнээр мэдээ дамжуулах хурд, багтаамж нэмэгдсэн төдийгүй, 20 аймгийн төвтэй шууд утсаар холбогдож, мэдээ хүлээн авах, дамжуулах боллоо.

Байгаль орчны үнэлгээ, хяналт-шинжилгээний талаар

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг хянах 4 харуул ажиллаж, нийт 166 сорьц авч хүхэрлэг хий болон азотын давхар ислийн агууламжийг тодорхойлов.

Энэ сард Байгаль орчны шинжилгээний төв лабораторид 24 сорьц, Туул голын дагуу 13 сорьц авч гидрохимийн болон бохирдлын үзүүлэлтүүдийг тодорхойлоод байна.

Байгаль орчны сайдын тушаалаар батлагдсан уул уурхайн олборлолт явуулж буй аж ахуй нэгжүүдийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан, 2004 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, эдэлбэр газрын нөхөн сэргээлтийн ажлын үнэлгээний шинжилгээ, хянан магадлагаа хийх ажлын хэсэг Төв аймгийн Заамар, Сэргэлэн, Булган аймгийн Бүрэгхангай сумуудад ажиллалаа. Мөн Дархан-Уул, Сэлэнгэ аймагт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 60 орчим аж ахуйн нэгжид ашигласан газрын нөхөн сэргээлтийн ажлыг шалгаж дүнг нэгтгэж байна.

Мод, модон материал борлуулах захуудад шалгалт хийж Цайз ХХК, Цолмонбадрах ХХК, Доной ХХК, Улаанбаатар төмөр замын ачиж буулгах цэгт мод модон материалын төрөлжсөн үйлчилгээний стандарт хангаагүй зөрчил илэрсэн тул үйл ажиллагааг түр зогсоох арга хэмжээ авлаа.

Бусад асуудлаар

“Түлээний модонд гарал үүслийн гэрчилгээ олгох тухай”, “Ойн зөрчил” сэдвүүдээр хэвлэлийн бага хурлыг зохион байгуулав.

“Яргайтын ам” орчинд хууль бусаар ой сүйтгэх, модны хулгайн зөрчил ихсэх хандлагатай байгаатай холбогдон УИХ-ын гишүүд, Ерөнхий сайд, хэвлэл мэдээллийн байгууллагуудын төлөөлөл оролцсон чөлөөт ярилцлага хийлээ. Мөн “OPEN-GOV - chat” ярилцлага, Монголын радиогийн “Экологийн дуран” нэвтрүүлэг, Монгол телевизийн “Нүүр тулсан ярилцлага” нэвтрүүлэг зэрэгт Байгаль орчны сайд оролцож иргэдтэй байгаль экологийн асуудлаар санал солилцлоо.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТ

Стратегийн удирдлагын хүрээнд

40000 айлын орон сууцны барилга барих ажлын хүрээнд орон сууцны хорооллыг нягтруулах судалгаа, орон сууцны хөтөлбөр хэрэгжих гэр хорооллуудыг сонгож тогтоох, орон сууцны хороолол барихаар сонгосон газруудын инженер-геологи, экологийн нөхцөл, онцлогуудын судалгааны ажлуудыг Улаанбаатар хотын дүүрэг нэг бүрээр гарган нэгтгэж байна.

Ойрын жилүүдэд ашиглалтад орох болон шинээр барихаар төлөвлөж байгаа орон сууцны барилгуудын судалгааг Улаанбаатар хот болон Монгол Улсын тулгуур төв 8 хотын хэмжээнд гарган, эдгээр хотуудын хүн амыг ойрын үед орон сууцаар хангах санал, төслийн хувилбарыг боловсруулж байна.

Монгол Улсын бүсчлэл, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан “Орон сууц” хөтөлбөрийн хамрах хүрээ, байршлын схемийн тооцоо, судалгааг гарган нэгтгэх ажлыг хийж байна.

“Орон сууц” хөтөлбөрт хамрагдах дагуул хотууд болон шинэ суурьшлын бүсийн техникийн шийдлийн төслийг боловсруулж эхлэн, энэ оны 12 дугаар сард дуусгаж, шалгарсан төслийг хэрэгжүүлж эхлэхээр бэлтгэж байна.

Монгол Улсын засаг захиргааны оновчтой хувилбар боловсруулах ажлын хүрээнд бүх аймаг, хотуудын суурь судалгааг эдийн засаг, нийгэм, хүн ам, дэд бүтцийн хөгжил, хэтийн хөгжлийн төлөв, байгаль экологийн онцлог зэрэг чиглэлээр авч боловсруулалт хийж байна.

“Ипотекээр баталгаажсан үнэт цаасны болон үйл ажиллагаа явуулах нэгжийн тухай”, “40000 айлын орон сууцны хөтөлбөртэй уялдуулан татварын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг боловсруулж байна.

Бодлогын зорилтыг зохицуулах ажлын хүрээнд

Монгол Улсын бүсийн тулгуур төв 8 хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ажлын явцыг хот тус бүрээр гаргав.

Хот байгуулалт, орон сууцны салбарт Азийн хөгжлийн банкнаас баримтлах стратеги боловсруулах зөвлөх үйлчилгээний техник туслалцааны төслийн ажлын хэсэг, Азийн хөгжлийн банкны хөтөлбөрийн ажлын хэсгийн төлөөлөгчдийн сайдтай уулзах уулзалтыг зохион байгуулж, төслийн зөвлөхүүдийн ажлын байр, тоног төхөөрөмжийн асуудлыг зохицуулах шийдвэрлэв.

Одоо баригдаж байгаа амины болон нийтийн зориулалттай орон сууцны судалгаа гаргаж, Нийслэлийн Засаг дарга, дүүргүүдийн газрын албадаас 2000-2004 онуудад орон сууц барих зориулалтаар олгосон газрын судалгааг нэгтгэж гаргав.

ТҮЛШ, ЭРЧИМ ХҮЧ

Бодлого, зохицуулалтын чиглэлээр:

Нүүрс тээвэрлэлт, вагон хангамжийн асуудлаар Багануур, Шарын голын уурхайнууд, ДЦС-4, УБТЗ-ын болон ТБЗГ-ын удирдлагууд оролцсон ярилцлагыг зохион байгуулж, протоколоор шийдвэр гарган, биелэлтэд хяналт тавьж ажиллав.

Эрчим хүчний үйлдвэр, компаниудын 2004-2005 оны өвөлжилтийн бэлтгэл ажил, их засвар, ТЗБАХ-ний төлөвлөгөөний биелэлтийн талаар хэлэлцэж, шийдвэрийн биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

Мөн өвлийн бэлтгэл ажил нь хүндрэлтэй байгаа дизельтэй 3 аймаг /Завхан, Говь-Алтай, Баянхонгор/-ууд Эрчим хүчний үйлдвэрүүд, Даланзадгадын ДЦС, Багануурын ДС-ын талаарх асуудлуудыг шийдвэрлэв.

Төрийн ордны цахилгаан хангамж тасарсан шалтгааныг тогтоох ажлын хэсэг зохион байгуулж, тасралтын шалтгааныг тодруулан, аваарын дизель станцын ажиллагааг шалган дүгнэлт гаргав.

Улаанбаатар хотын цахилгаан хангамжийг найдваржуулах зорилгоор зайлшгүй солих шаардлагатай олон жил ашиглагдсан, олон муфттэй кабелиудыг солих санал боловсруулж, санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

Баянхонгор, Говь-Алтай аймгийн эрчим хүчний үйлдвэрүүдэд Хөвсгөлийн эрчим хүчний үйлдвэрээс шилжүүлсэн Шкода маркийн 4 дизель цахилгаан станцыг ашиглалтад орууллаа.

Алтай-Тайширын УЦС-ыг холбох 35 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд өртөөний барилга угсралтын ажлыг ашиглалтад хүлээн авлаа.

Тайширын УЦС-Улиастай 110 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд өртөөний барилга угсралтын ажлын гүйцэтгэгч хятадын Бээжингийн эрчим хүчний угсралтын компанийн мэргэжлийн хүмүүсийг шугамын трассын дагуу ажиллах ажлыг зохион байгуулав.

БНХАУ-ын Засгийн газрын 50 сая юанийн буцалтгүй тусламжийн хүрээнд авсан 20620 комплект нарны цахилгаан үүсгүүрийг аймаг сумуудад хуваарлан олгов.

Хамтын ажиллагааны чиглэлээр:

Дэлхийн банкны Түлш, эрчим хүчний салбарын ерөнхий менежер Жунхуй Ву, Японы Мицуй болон Иточу компаний төлөөлөгчид, ОХУ-ын Эрхүү мужийн амбан захирагч Б.Говорин зэрэг томоохон гадаадын зочид төлөөгчидтэй албан ёсны уулзалтуудыг зохион байгуулав.

БНЧУ-ын буцалтгүй тусламжаар “ДЦС-4” ХК-ийн түлш дамжуулах цехийн 4 дүгээр туузан дамжлагын удирдлага-хяналтын системийг автоматжуулах ажлын эхний үе шатны ажил дуусаж ашиглалтад хүлээн авав. Тухайн ажлын эхний үе шат дууссантай холбогдуулан БНЧУ-ын үйлдвэр худалдааны сайдад талархал илэрхийлж, хамтын ажиллагааг цаашид үргэлжлүүлэх тухай албан тоот явуулсан.

Монгол Улсын “Эрчим хүчний тухай” хуулийн дагуу Монгол Улсын “төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ” төрийн өмчит хувьцаат компани, ОХУ-ын “ИНТЕР РАО ЕЭС” нийгэмлэгтэй гэрээ байгуулах ажлын хэсгийг томилон ажиллуулж, импортын цахилгаан эрчим хүчний гэрээг шинэчлэн байгуулав.

ЗАМ ТЭЭВЭР, АЯЛАЛ ЖУУЧЛАЛ

Бодлого боловсруулах, зохицуулах талаар

Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбогдуулан Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн Монголын талын Ерөнхий хувь нийлүүлэгчийг өөрчлөх тухай Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн Монголын талын ерөнхий хувь нийлүүлэгч Зам тээвэр, аялал жуулчлалын сайдыг томилов.

Хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн Ерөнхий хувь нийлүүлэгчдийн ээлжит болон ээлжит бус хуралдаан, Удирдах зөвлөлийн хуралдаан, мөн тус нийгэмлэгийн хоёр талын хянан шалгах комиссын хурлыг зохион байгуулж, тус комиссын ажлыг дүгнэн, Удирдах зөвлөл, хянан шалгах комиссын бүрэлдэхүүнийг өөрчлөх зэрэг олон асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв.

Мянганы сорилтын сангийн хөрөнгөөр Монгол Улсын баруун босоо тэнхлэгийн Ховдын Булган-Ховд-Өлгий-Улаанбайшинт чиглэлийн авто замыг барих, Улаанбаатар-Эрдэнэсантын чиглэлийн 176 км хатуу хучилттай авто замыг шинэчлэх төслүүдийг боловсруулан холбогдох газарт хүргүүлсний дүнд Улаанбаатар-Эрдэнэсантын чиглэлийн авто замын шинэчлэлт төслийг эхний ээлжинд сонгож аваад байна.

“Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх зорилгоор Азийн хөгжлийн банкт байгуулсан санамж бичгийн заалтыг хэрэгжүүлэх, Азийн авто замын сүлжээнд нэгдэн орсонтой холбогдуулан авто тээврээр хилээр дамжин өнгөрүүлэх үйл ажиллагаатай холбоо бүхий байгууллагуудын хоорондын ажлын уялдааг сайжруулах, шаардлагатай зохицуулалтыг хийж хамтран ажиллаж байх ажлын хэсгийг байгуулахаар арга хэмжээ авч байна.

Монгол Улсын Авто замын сүлжээний атласыг хэрэглэгчдэд зориулан тоон технологийн үндсэн дээр боловсруулан хэвлүүлж, техникийн зөвлөлөөр оруулан авто замын салбарын өмч болгох шийдвэр гаргууллаа.

“Аялал жуулчлалын салбар дахь гадаад харилцааг өргөжүүлэх зорилгоор “Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Украин Улсын Сайд нарын танхим хоорондын Хэлэлцээр”-ийг урьдчилан тохироод байна.

Аялал жуулчлалын үйлчилгээний чанарыг олон улсын жишигт ойртуулах зорилгоор “Аялал жуулчлал, байрны төрлийн үндсэн нэр томъёоны стандарт”-ын төслийг боловсруулан Аялал жуулчлал, зочид буудлын стандартчиллын дэд хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулахаар болов.

Монгол-Австрийн Засгийн газар хоорондын комиссын анхдугаар хуралдааны мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх, аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор Монгол Улсаас Австри Улсад суугаа ЭСЯ-нд аялал жуулчлалын экспертүүдийн хэмжээнд дугуй ширээний ярилцлага уулзалтыг зохион байгуулахаар тохиролцлоо.

Соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор “Монголд соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх нь” олон улсын бага хурлыг Монголын Урлагийн зөвлөл, МАЖХ, Нээлттэй нийгэм Соросын сан, АНУ-ын ОУХА-ийн Эдийн засгийн шинэчлэл ба өрсөлдөх чадвар төсөлтэй хамтран зохион байгуулав. Тус бага хурын үр дүнд Монгол соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулав.

2004 оны эхний 10 сарын жуулчдын тоо, аялал жуулчлалын салбарын орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулсан статистикийн мэдээг нэгтгэн гаргав. Одоогийн байдлаар жуулчдын тоо 262524 болсон нь өмнөх оны мөн үеэс 50.9%-аар, өсч, аялал жуулчлалын салбарын орлого 224.2 сая ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 72.4%-аар өссөн дүн харагдаж байна.

“Хаяг тодорхойгүй болон шуудангаар илгээхийг хориглосон зүйл агуулсан илгээмжийг түр хадгалах, задлах, шалгах журам”-ын төслийг боловсруулаад байна.

Бодлогын зохицуулалт, хэрэгжилтийн талаар

БНХАУ-ын ӨМӨЗО-ны Тээврийн танхимын төлөөлөгчидтэй 2005 оны ачаа, зорчигч тээвэрлэлт гүйцэтгэх, тээвэрлэлтийн зөвшөөрлийн бичиг солилцох ажлын уулзалтыг зохион байгуулав.

БНТУ-ын Тээврийн яамнаас тавьсан хүсэлтийн дагуу “Олон улсын авто тээврийн харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, БНТУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг хэрэгжүүлэхэд баримтлах нарийвчилсан журмын төслийг тохиролцон, гарын үсэг зурав.

Хагас вагоны хүрэлцээ муу болон Шарын голын уурхайн төмөр замыг хаасан зэрэг байдлаас шалтгаалан Дарханы ДЦС, Эрдэнэтийн ДЦС нь 7-10 хоногийн нүүрсний нөөцтэй болоод байгаа бөгөөд станцуудын сарын нөөцтэй байх график тасарч, өвлийн ид ачааллын үеэр ноцтой хүндрэлүүд гарч болзошгүй байгааг анхааралдаа авч тус уурхайг хоногт 40 вагоноор хангаж, нүүрс нөөцлөлтийг хэвийн хэмжээнд хүргэж, хэрэгжилтийн явцыг танилцуулж байхыг хувь нийлүүлсэн “УБТЗ” нийгэмлэгт даалган хяналт тавьж ажиллаж байна.

Япон Улсын буцалтгүй тусламжийн хүрээнд 2000-2004 онуудад нийт 2.067 сая иений өртөг бүхий “Төмөр замын байгууламжийг сэргээн сайжруулах” төслийг бүрэн хэрэгжүүлж дууссаныг албан ёсоор хүлээн авлаа.

Европын сэргээн босголт, хөгжлийн банкны Техникийн хамтын ажиллагааны хүрээнд “МИАТ” ХК-ийн удирдлагыг гадаадын менежментийн багаар гүйцэтгүүлэх төсөл хэрэгжиж дууссантай холбогдуулж, компанийн удирдлагыг Ирланд Улсын АСI компаниас шинээр томилогдсон гүйцэтгэх захиралд хүлээлгэн өгөх ажлыг зохион байгууллаа.

Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг дахь Хэрлэн голын 186.9 у/м, 18.5 у/м модон гүүрүүдийг улсын ашиглалтад хүлээн авч, тээврийн хөдөлгөөн нээлээ.

Авто замын газарт байсан Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон замын сангийн хөрөнгийн дансуудыг хааж, яаманд төвлөрүүлэн, шинээр данс нээн өдөр тутмын гүйлгээг хийж байна.

Шуудангийн багц стандартыг СХЗТ-ийн техникийн хорооны хуралдаанаар батлуулав.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ

Стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах талаар:

“Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” болон “Төмс, хүнсний ногооны гаалийн татварын хэмжээг 4 сараас 8 дугаар сар хүртэл 10 хувиар нэмэгдүүлэх тухай хуулиудын төслийг боловсруулав.

“Мах үйлдвэрлэл, боловсруулалтын сүлжээг боловсронгуй болгох тухай” асуудал боловсруулав.

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Тогтвортой амьжиргаа” төслийн хөрөнгө оруулалтаар 2004 онд Баян-Өлгий, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Төв аймгуудад засварласан худгуудын үнийн дүнгийн 10 хувьтай тэнцэх хөрөнгийг сайдын төсвийн багцаас гаргаж, 29.7 сая төгрөгийг Төрийн сан дахь “Тогтвортой амьжиргаа” төслийн дансанд шилжүүлэх санал гаргаад байна.

ХХАА-н сайд БНХАУ, БНУУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайдууд болон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Монгол дахь суурин төлөөлөгч Пратибха Мета тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав.

Увс аймагт хийгдэж байгаа усалтын систем сэргээн засварлах ажлын гүйцэтгэлд захиалагчийн хяналт хийж, ашиглалтад хүлээн авлаа.

Баянхонгор, Өвөрхангай, Дорноговь аймагт хийгдсэн худгийн засвар шинэчлэлтийн болон шинээр худаг гаргах ажлын эцсийн санхүүжилт олгох ажлыг зохион байгуулж, Архангай, Завхан аймагт сэргээн засварлах худгийн санхүүжилтийн эрхийг нээлгэв.

Бодлогын хэрэгжилтийг зохицуулах ажлын талаар

Өвөлжилт хүндэрч болзошгүй аймгуудаас ирүүлсэн санал хүсэлтийг судалсны үндсэн дээр шийдвэрлэх талаар санал боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэв.

“Бод малыг индексжүүлсэн тамганы сүлжээнд хамруулах журам”-ын төсөл боловсруулж, энэ талаар семинар зохион байгуулав.

Мал эмнэлгийн эмийн үйлдвэрлэл эрхлэх эм импортлох чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд тусгай зөвшөөрөл олгуулав.

Согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн материалыг хянаж, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хугацааг сунгах, хүчингүй болгох, нөхөн олгох, сэргээх тухай тушаал гаргав.

“Архи, ликёр, дарс үйлдвэрлэх технологийн дамжлагад гарах спиртийн хорогдлын норм”, “Спирт хүлээн авах, шилжүүлэх, хадгалах, тээвэрлэхэд гарах хэвийн хорогдлын норм” шинэчлэн батлагдсантай холбогдуулан семинар зохион байгуулав.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс ирүүлсэн өргөдлийн дагуу согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий зарим архины үйлдвэрийн бичиг баримтыг хянаж шийдвэрлэв.

Мах боловсруулах жижиг үйлдвэрүүдийн хэмжээнд мөрдөх стандартыг шинэчлэх, итгэмжлэлийн зэрэглэлд хамруулах, мал эмнэлэг, ариун цэврийн дүрэм боловсруулах асуудлыг ажлыг хэсэгтэй хамтран боловсруулж, итгэмжлэлийн зэрэглэлийн шалгуур үзүүлэлтүүдийг гаргав.

Мах боловсруулах, борлуулах сувгийг хөгжүүлэх 10 жилийн хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг “ТАСИС” хөтөлбөртэй хамтран байгуулж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний асуудлаар хамтран ажиллаж байна.

Сүүний хөргөлтийн тоног төхөөрөмж, зохиомол хээлтүүлгийн техник төхөөрөмжөөр мэргэшсэн Францын компанийн төлөөлөгчидтэй уулзалт зохион байгуулав.

Баяжуулсан гурил үйлдвэрлэх бага оврын үйлдвэрүүдтэй танилцах ажлыг зохион байгуулж, 2-р шатны хөрөнгө оруулалтын хуваарилалтыг АХБ-ны Төслийн бүлэгтэй хамтран боловсруулав.

“КР-1”, “КР-2” төсөл, “Үр дэд хөтөлбөр”-ийн хүрээнд газар тариалан эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд өгсөн зээлийн өрийг барагдуулах ажлыг эрчимжүүлэн, “Өр барагдуулах ажлын хэсэг”-ийг шинэчлэн зохион байгуулав.

БАТЛАН ХАМГААЛАХ

Стратегийн удирдлага, төлөвлөлтийн чиглэлээр:

"Цэрэг, цагдаагийн албан хаагчийг НҮБ-ын Энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийн төслийг дахин хэлэлцэж шинэчлэн боловсруулав.

"Зэвсэгт хүчнийг энхийг сахиулах ажиллагаанд бэлтгэж оролцуулах хөтөлбөр"-ийг ЗХЖШ-тай зөвшилцөж эцэслэн боловсрууллаа.

Батлан хамгаалахын сайдын 2004 оны 293 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг Төрийн цэргийн бодлого, цэргийн шинэчлэл, салбарын офицер, ахлагч, ажилтан албан хаагчдын нийгмийн хамгаалалын талаархи нээлттэй хэлэлцүүлгийг БХЯ, ЗХЖШ-ын удирдах бүрэлдэхүүн, Зэвсэгт хүчний анги байгууллагуудад зохион байгуулж, шинжилгээ хийн, судалгааны дүнг гаргаад байна.

Шинжлэх ухааны ажилтны өдрийг угтан салбарын эрдэмтэдтэй "Батлан хамгаалах салбарын тулгамдсан асуудал" сэдэвт нээлттэй ярилцлага зохион байгуулсан нь тулгамдсан асуудлыг дэвшүүлэх, шийдвэрлэх арга замыг тодорхойлоход чухал ач холбогдолтой, цаг үеэ олсон үр дүнтэй арга хэмжээ боллоо.

Батлан хамгаалахын сайд Б.Эрдэнэбат Австри Улсад ажлын айлчлал хийв.

Батлан хамгаалах салбарын гадаад арга хэмжээний төлөвлөгөөний дагуу, Монгол Улс, АНУ-ын батлан хамгаалах салбарын дээд хэмжээний уулзалт, ОХУ-ын цэрэг, техникийн хамтын ажиллагааны газрын төлөөлөгчид, Канад Улсаас Монгол Улсад хавсран суугаа Батлан хамгаалахын атташегийн ажлын айлчлалыг тус тус зохион байгуулан, Монгол Улс, БНСУ-ын тусгай хүчний хамтарсан дадлага сургуулийн бэлтгэл ажил хийгдээд байна.

Бодлогын хэрэгжилтийг зохицуулах чиглэлээр:

Энэ оны 11 дүгээр сарын 1-5-ны өдрүүдэд ОХУ-ын Тулийн "Конструкторское бюро приборостроения" УҮГ-ын ерөнхий инженерийн орлогч В.Трухачев тэргүүтэй төлөөлөгчид хүрэлцэн ирж, хэлэлцээрийн хүрээнд монголын талд тусламжаар үзүүлэх зарим нэр төрлийн цэрэг-техникийн эд зүйлсийн талаар харилцан тохиролцож, 11 дүгээр сарын 4-нд гэрээнд гарын үсэг зурсан.

Батлан хамгаалах салбарт ашиглагдаж байгаа зэвсэглэл, техникийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, шинэчлэлтийн төлөвийн тухай мэдээлэл бэлтгэн удирдлагыг цаг үеийн шуурхай мэдээллээр ханган ажиллав

Энэ сард Батлан хамгаалах яамны харьяа БХИС, ЗХКТГ, МЦМ, ЦДБЭЧ-ын төсвийн гадуурх орлогын давсан хэсэгт нэмэлт бүтээгдэхүүний гэрээ байгуулах, байгууллага хооронд төсвийн зохицуулалт хийх арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

Зэвсэгт хүчний сургалт бэлтгэл, бэлэн байдлын талаар

ЗХЖШ-ын удирдлага энэ сард Зэвсэгт хүчний зарим анги, салбаруудын байлдааны болон дайчилгааны бэлэн байдлыг шалгах, ЗХЖШ, түүний харьяа газар, хэлтсүүд болон аймаг, нийслэлийн цэргийн штабуудын "Байлдааны бэлэн байдлын дээд зэргүүдэд шилжүүлэх төлөвлөгөө"-г шинэчлэн боловсруулах, Зэвсэгт хүчний анги, байгууллагуудын цэргийн нөөцийн материал, хэрэгслийн судалгааг гаргаж дуусгах, 2005 онд Зэвсэгт хүчний анги, салбаруудын байлдааны бэлэн байдлыг шалгах төлөвлөгөөг боловсруулах ажлыг эхлүүлэх, 2004-2005 оны сургуулийн жилийн I үеийн цэргийн сургалт бэлтгэлийг эхлүүлэх ажлыг зохион байгуулах, цэргийн сургалт бэлтгэлийн үндсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу офицер, ахлагч нартай онолын бэлтгэлийг батжуулах шатны сургалт, гэрээт цэргийн I, II жилийн цэргийн албан хаагчидтай анхан шатны болон цэргийн ерөнхий бэлтгэл, мэргэжлийн гүнзгийрүүлсэн сургалт, хугацаат цэргийн албан хаагчидтай анхан шатны бэлтгэл, тасгийн жигдрэлтийг хангах сургалт болон 2004 оны 2 дугаар ээлжийн цэрэг халах, татах ажлыг зохион байгуулж мэргэжлийн

удирдлагаар хангах, Зэвсэгт хүчний анги, салбаруудын цэргийн албаны зохион байгуулалт, сахилга дэг журмыг дээшлүүлэхэд анхаарах, Улаанбаатар цэргийн хүрээний анги, байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл ажлыг шалгаж, хүлээн авах зэрэг ажлуудад гол анхаарлаа чиглүүлэн ажиллаа.

Сургалт бэлтгэл, бэлэн байдлын талаар

“Зэвсэгт хүчний анги, салбаруудын байлдааны болон дайчилгааны бэлэн байдлыг шалгаж үнэлэх заавар”-ыг шинэчлэн боловсруулж, Зэвсэгт хүчний зарим ангиудын байлдааны болон тусгай үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг шалгаж үнэллээ.

Зэвсэгт хүчний анги, байгууллагуудын нөөцийн материал хэрэгслийн судалгааг гаргах ажлыг үргэлжлүүлэн хийж, 2004-2005 оны сургуулийн жилд Зэвсэгт хүчний анги, салбаруудын байлдааны болон дайчилгааны бэлэн байдлыг шалгах нэгдсэн төлөвлөгөөг боловсруулсны гадна “Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний бие бялдрын бэлтгэлжилтийн шалгуур үзүүлэлт”-ийг шинэчлэн боловсруулж батлууллаа.

ЗХЖШ-ын даргын тушаалаар ажлын хэсэг томилж, Нийслэлийн нутаг дэвсгэрт Батлан хамгаалах зориулалтаар газар эзэмшиж буй ерөнхий зориулалтын цэргийн анги, байгууллагуудын эзэмшил газарт Газрын харилцаа, геодези, зураг зүйн газартай хамтарсан үзлэг тооллогыг хийх ажлыг эхлүүлээд байна.

“Барьцаалагдсан хүн, объектыг хүч хэрэглэх замаар чөлөөлөх үеийн тусгай томилгоот салбаруудын харилцан ажиллагаа” сэдвээр Хүчний байгууллагуудын хамтарсан сургалт, дадлагыг 2 үе шаттайгаар зохион байгуулж явууллаа. Сургалт, дадлагад Зэвсэгт хүчний 2, ТЕГ-ын 1, ЦЕГ-ын 1 бүлэг оролцож, тавьсан зорилгоо биелүүлж, дараагийн шатанд явуулах сургуулийн сэдэв, зорилго, боловсруулах асуудлыг хамтран тодорхойллоо.

2004 оны II ээлжийн цэрэг халах татах ажиллагааг 11 дугаар сарын 1-ээс 10-ны өдрүүдэд осол, аваар, гэмт хэрэг зөрчилгүй амжилттай зохион байгуулав. Энэ удаагийн цэрэг татлагаар Ерөнхий зориулалтын цэрэгт 1252 хүнийг татаж хяналтын тоог 96.3 хувиар, гэрээт цэргийн албанд 57 хүнийг элсүүлэн авч хяналтын тоог 43,8 хувиар тус тус биелүүллээ.

Зэвсэгт хүчний анги, байгууллагуудад 11 дугаар сарын 15-наас 2004-2005 оны сургуулийн жилийн I үеийн цэргийн сургалт бэлтгэлийг эхлүүлж, сургуулийн салбарт шинэ дайчдын анхан шатны бэлтгэл, сургууль-байлдааны салбарт тасгийн жигдрэлтийг хангах сургалт явагдаж байна. Улаанбаатар цэргийн хүрээний анги, салбаруудын шинэ сургуулийн жилийн нээлтийн ажиллагаанд ЗХЖШ-ын удирдлагууд, газар, хэлтсийн дарга нар оролцлоо. Шинэ дайчид анхан шатны бэлтгэлээ дуусгаад 11 дугаар сарын 28-ны өдөр цэргийн тангараг өргөнө.

“Иракийн эрх чөлөө” Олон улсын ЭСА-нд оролцож буй манай цэргийн багийн бүрэлдэхүүн “Чарли” баазад, “Афганистаны үндэсний армийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд Сургалтын хөдөлгөөнт багийн 3 дахь ээлжийн бүрэлдэхүүн Афганистаны Кабул хотод үүргээ амжилттай гүйцэтгэж байна.

Монгол Улс, АНУ-ын цэргийн албан хаагчдын хамтарсан “Хааны эрэлд” Энхийг сахиулах ажиллагааны хээрийн сургуулийн анхан шатны төлөвлөлтийн бага хурлыг Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулав.

Монгол Улсын Ерөнхийлөгч, ЗХЕК Н.Багабанди ЗХЖШ-т зочилж, ЗХЖШ-т шинэхэн төхөөрөмжилсөн Байлдааны ажиллагааны сургалтын танхим, АДХЦ-ийн шугамаар хэрэгжүүлж буй “Дэлгэц” төслийн хэрэгжилттэй танилцлаа.

ГАДААД БОДЛОГО

Стратегийн удирдлагын мэдээлэл

УИХ-ын дарга Н.Энхбаяр Их Британид ажлын айлчлал хийв.

УИХ-ын дарга Н.Энхбаяр Норвегийн Гадаад хэргийн дэд сайдтай уулзалт хийсэн.

Украины Эдийн засаг, Европын интеграцийн асуудал эрхэлсэн сайд В.Пятницкий Монгол Улсад айлчлал хийсэн.

АНУ-ын төрийн туслах нарийн бичгийн дарга Ж.Келлийн Монголд айлчлав.

УИХ-ын урилгаар Чехийн парламентын Хууль зүйн байнгын хорооны дэд дарга тэргүүтэй төлөөлөгчдийн 10 дугаар сарын 24-29-нд Монголд айлчлал хийлээ.

Тайландын Гадаад хэргийн сайдын тусгай элч В.Ниссай тэргүүтэй төлөөлөгчид айлчлав. Төлөөлөгчид айлчлалын үеэр Газрын мини хориглох тухай Оттавагийн Конвенцийн асуудлаар манай холбогдох хүмүүстэй уулзаж ярилцав.

АНУ, Монголын БХЯ-д хоорондын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, оролцов.

НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Дээд комиссариатын газрын /ДАЭДКГ/ бүсийн төлөөлөгч Мишель, БНСУ-ын Эв нэгдлийн яамны Суурьшилд дэмжлэг үзүүлэх хэлтсийн дарга Жон Дон Мюн нартай “дүрвэгсэд”-ийн асуудлаар уулзалт хийв.

Удирдлага зохицуулалтын мэдээлэл

БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хот дахь Консулын салбарыг Консулын газар болгон өөрчлөн байгуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэв. Эрээн дэх Консулын газрын үзэл баримтлалыг боловсрууллаа.

Монгол Улсын Засгийн газар Японд болсон байгалийн гамшигт нэрвэгдсэн хүмүүст 10 сая төгрөгийн эд материалын тусламж үзүүлэх талаар холбогдох яам, газруудаас санал авч, уг асуудлыг Засгийн газрын хуралдаанд оруулж, шийдвэрлүүлэв. Тусламжийн 520 ширхэг ноосон хөнжлийг МИАТ-ийн онгоцоор тээвэрлэн Токиод суугаа Монгол Улсын ЭСЯ-аар дамжуулан японы талд гардуулав.

2005 оныг “Бичил санхүү, жижиг, дунд бизнесийг дэмжих жил” болгон зарлах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулав.

Камбожид болсон АРФ-ын итгэлцлийг бэхжүүлэх чуулган хоорондын ажлын хэсгийн уулзалт болон Бээжин хотноо болсон АРФ-ын “Азийн аюулгүй байдлын бага хурал”-д тус тус манай төлөөлөгчид оролцов.

Баруун Сахар дахь НҮБ-ын энхийг сахиулах үйл ажиллагаанд ажиглагчаар оролцож байгаа манай хоёр албан хаагчийн сэлгээний асуудал болон Бангладешийн Дака хотноо болох энхийг сахиулах ажиллагааны сургагч нарт зориулсан хүний эрхийн асуудлаарх семинарт төлөөлөгч оролцуулах асуудлыг холбогдох байгуулагуудтай хамтран шийдвэрлэв.

Бангкок хотноо болсон Хүүхдийг садар самуунд татан наймаалахын эсрэг асуудлаарх Зүүн Ази, Номхон далайн бүсийн орнуудын Ёкохама-гийн тунхаглал, үйл ажиллагааны төлөвлөгөөний дунд хугацааны биелэлтийг хэлэлцэх хуралдаанд оролцох Засгийн газрын төлөөлөгчдийн /ХЗДХЯ, НХХЯ, ГХЯ болон ХТҮГ-ын/ бэлтгэлийг хангаж, оролцов.

Фижи Улсад болсон Ази Номхон Далайн улсуудын 9 дүгээр зөвлөлдөх уулзалтад тус яамнаас төлөөлөгч оролцуулав.

1992 онд байгуулсан “Хоёр талын эдийн засгийн гадаад харилцааны тухай Монгол Улс, Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийн зарим зүйл заалтыг хүчингүйд тооцох тухай хуулийг УИХ 2004 оны 10 дугаар сарын 22-ны өдөр баталсныг австрийн талд мэдэгдэв.

БНСВУ-ын ЭСЯ-ны хашаанд хүн амины хэрэг гарсантай холбогдуулан тус улстай байгуулсан Эрхийн туслалцааны гэрээ, Венийн конвенциудыг судалж, дүгнэлт бэлтгэв. Монгол Улс, БНСВУ-ын хооронд иргэн, гэр бүлийн болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай Гэрээ, Дипломат харилцааны тухай Венийн Конвенц, БНСВУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-ны эдэлбэр газрын зургийн хуулбарыг Улсын мөрдөн байцаах газарт хүргүүлэв.

Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай 1951 оны Конвенц, түүний 1967 оны Протоколд нэгдэн орох асуудлаар дүгнэлт гаргах ажлын хэсгийн анхдугаар хуралдааныг зохион байгуулав.

Дамжин өнгөрөх тээврийн асуудлаар Женев хотноо болох гурван талт хэлэлцээний үеэр манай талаас баримтлах байр суурийг боловсруулах ажлын хэсгийг хуралдуулав.

Шүүрхай мэдээ

2004 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн БНХАУ-ын ЗСОБ-ийн Засгийн газар хооронд иргэд харилцан зорчих хэлэлцээрийн дагуу бүх төрлийн паспорттай хоёр улсын иргэд 90 хоногийн хугацаанд харилцан визгүй зорчих асуудлыг шийдвэрлүүлэв.

ОХУ-ын шоронд хорих ял эдэлж буй Монгол иргэдийн байдалтай ОХУ-д суугаа ЭСЯ-ны дэд консул явж танилцах ажлыг зохион байгуулав.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРЭГ

Стратегийн удирдлагын мэдээлэл

Хүүхдийн итгэлийн мөнгөний тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг хуулийн төслүүдийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцлээ.

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай, Засгийн газрын бүтцийн тухай хуулиуд болон “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай” УИХ-ын тогтоол батлагдаж, Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан Ашигт малтмалын тухай, Аялал жуулчлалын тухай, Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай, Шуудангийн тухай зэрэг 30 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулаад байна.

Удирдлага, зохицуулалтын мэдээлэл

ХЗДХ-ийн сайд Ц.Нямдорж АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Памела Слүц нар Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Засгийн газар хооронд байгуулсан Хар тамхитай тэмцэх болон хууль хэрэгжүүлэх талаарх 2000 оны Харилцан ойлголцлын санамж бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протоколд гарын үсэг зурлаа. Уг санамж бичигт нэмэлт, өөрчлөлт орсноор АНУ-ын Засгийн газраас Монголын цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, эрүүгийн цагдаагийн газрын удирдлага, албан хаагчид зэрэг 60 хүнд хуурамч мөнгөн тэмдэгтийг илрүүлэх талаар нийт 40 мянган ам.долларын өртөг бүхий 7 хоногийн сургалт зохион байгуулж, техникийн туслалцаа үзүүлэх юм.

Сайд Ц.Нямдорж БНАСАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Пак Жон До-г хүлээн авч уулзан, сүүлийн жилүүдэд зогсонги байдалд ороод байгаа хоёр орны эрх зүйн салбарын харилцааг цаашид хөгжүүлэх талаар ярилцав.

Гадаад улсуудтай байгуулсан эрх зүйн туслалцааны гэрээний дагуу ОХУ, Чех Улсын Хууль зүйн яам, Дотоод хэргийн яамнаас тус тус ирүүлсэн шүүхийн 2 даалгавар, 1 өргөдөлд холбогдох ажиллагааг гүйцэтгэсний зэрэгцээ шүүхийн 2 даалгаврын ажиллагааг бүрэн дуусгасан байна.

ХЗДХЯ-ны Гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүмүүсийн асуудлаарх ажлын хэсгийн хүрээнд ял эдэлж буй хүүхдийн эрхийг хамгаалах, тэдэнтэй харьцах сэтгэл зүйн харицааны онцлог, уламжлалт сурган хүмүүжүүлэх арга ухааны асуудлаар хүүхдийн хорих 411-р анги, эмэгтэйчүүдийн хорих, цагдан хорих 461-р ангийн албан хаагчдад зориулсан сургалт семинар, Хүүхдийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах судалгааны ажлын үр дүнг хууль сахиулах болон хүүхдийн байгууллага, эрдэмтэн судлаач нарт танилцуулах уулзалт ярилцлагыг тус тус зохион байгуулав. Эдгээр нь Гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүмүүсийн асуудлаарх ажлын хэсгээс 2004 онд хийсэн ажлыг нэгтгэн тайлагнах, үр дүнг үнэлэх, цаашид хийх үйл ажиллагааг төлөвлөхөд ихээхэн ач холбогдолтой боллоо.

“Худалдааны эрх зүй-Монгол Улс дахь өнөөгийн байдал, бусад улсын туршлага”, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг боловсронгуй болгох нь”, “Хуулийн төсөл боловсруулах арга зүй, ур чадварыг нэмэгдүүлэх нь” сэдэвт семинар аймаг нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын эрх зүйн сургалт, сурталчилгааны асуудал эрхэлсэн ажилтнуудын сургалт, семинарыг тус тус зохион байгууллаа.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР